

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2025/002/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Говьсүмбэр аймаг</p> <p>2025 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543179, Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn Аудитор: С.Батцэцэг Цахим хаяг: battsetsegsa@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу..

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govsummer@audit.gov.mn

Г ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ТОХИЖИЛТ СҮМБЭР ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Ц.ЭНХЖАРГАЛ ТАНАА

2025.03.17 № 52
танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн орлого, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Говьсүмбэр аймгийн “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн байдал, орлого үр дүн, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

422502211

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	87,296,695.66	151,893,678.33
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	18,246,838.66	14,463,870.29
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	18,246,838.66	14,463,870.29
31210	Төгрөг	18,246,838.66	14,463,870.29
31213	Арилжааны банк дахь харилцах	18,246,838.66	14,463,870.29
33	АВЛАГА	34,194,657.00	34,528,880.04
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	53,818.00	0.00
33500	Бусад авлага	34,140,839.00	34,528,880.04
33510	Байгууллагаас авах авлага	34,081,839.00	34,528,880.04
33520	Хувь хүмүүсээс авах авлага	59,000.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	34,855,200.00	102,900,928.00
35400	Хангамжийн материал	34,855,200.00	102,900,928.00
35420	Аж ахуйн материал	34,855,200.00	102,900,928.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	11,947,648,251.13	12,583,067,843.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,947,648,251.13	12,583,067,843.84
39200	Биет хөрөнгө	11,729,061,970.76	12,363,572,000.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,690,024,020.80	2,690,024,020.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	-40,356,982.03	-329,723,336.03
39203	Авто-тээврийн хэрэгсэл	854,462,000.00	1,079,162,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-338,320,266.30	-437,304,966.09
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	15,256,000.00	30,680,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-7,626,158.15	-12,615,548.23
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,482,328.57	11,082,328.57
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,620,565.93	-5,987,286.47
39209	Зам, гүүрийн байгууламж	7,540,060,615.00	7,540,060,615.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-2,181,241,384.52	-2,633,284,185.03
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,480,449,948.00	7,880,891,893.87
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,285,507,584.68	-3,912,073,907.10
39300	Биет бус хөрөнгө	218,586,280.37	219,495,843.56
39301	Програм хангамж	20,118,374.00	20,118,374.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-14,239,593.68	-18,122,530.44
39303	Бусад биет бус хөрөнгө	317,890,000.00	317,890,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-105,182,499.95	-100,390,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	12,034,944,946.79	12,734,961,522.18

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,278,403,255.06	11,464,754,413.13
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	61,900.00	706,850.00
41300	Өглөг	61,900.00	706,850.00
41360	Бусад өглөг	61,900.00	706,850.00
41361	Байгууллагад төлөх өглөг	61,900.00	706,850.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,278,341,355.06	11,464,047,563.13
42200	Урт хугацаат зээл	10,278,341,355.06	11,464,047,563.13
42210	Төгрөг	10,278,341,355.06	11,464,047,563.13
42241	Хойшлогдсон өр төлбөр /ТӨҮГ/	10,278,341,355.06	11,464,047,563.13
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,756,541,691.73	1,756,541,691.73
51	Засгийн газрын хувь оролцоо	1,756,541,691.73	1,756,541,691.73
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,202,002,208.14	2,202,002,208.14
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,202,002,208.14	2,202,002,208.14
51200	Хуримтлагдсан үр дүн	-452,265,847.29	-938,600,429.97
51210	Өмнөх үеийн үр дүн	401,111,378.54	-447,265,847.34
51220	Тайлант үеийн үр дүн	-853,377,225.83	-491,334,582.63
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,805,330.88	6,805,330.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	12,034,944,946.79	12,734,961,522.18

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,070,334,737.21	1,417,386,333.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,070,334,737.21	1,417,386,333.78
120	Нийтлэг татварын бус орлого	1,070,334,737.21	1,417,386,333.78
120009	Бусад орлого	910,881,700.00	1,179,156,570.00
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	159,453,037.21	238,229,763.78
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,911,711,963.04	1,836,520,003.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,911,711,963.04	1,836,520,003.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,911,711,963.04	1,836,520,003.05
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	1,911,711,963.04	1,836,520,003.05
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-841,377,225.83	-419,133,669.27
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	12,000,000.00	72,200,913.36
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	12,000,000.00	72,200,913.36
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-853,377,225.83	-491,334,582.63

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,000,467,473.21	1,415,222,378.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,000,467,473.21	1,415,222,378.74
120	Нийтлэг татварын бус орлого	1,000,467,473.21	1,415,222,378.74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	93,423,773.21	297,293,550.74
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	89,487,305.00	246,790,762.96
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,936,468.21	50,502,787.78
120009	Бусад орлого	907,043,700.00	1,117,928,828.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,009,990,091.58	1,409,555,347.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,009,990,091.58	1,409,555,347.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,009,990,091.58	1,409,555,347.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	337,216,483.00	498,910,255.00
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	337,216,483.00	498,910,255.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,631,030.91	96,297,143.49
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	97,631,030.91	96,297,143.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,253,163.48	109,070,615.28
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	70,253,163.48	109,070,615.28
2104	Хангамж, бараа материалын зардал	186,457,983.00	265,571,486.20
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	186,457,983.00	265,571,486.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	318,431,431.19	323,339,270.94
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	28,185,486.85	44,224,902.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	290,245,944.34	279,114,368.94
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-9,522,618.37	5,667,031.63
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,500,000.00	9,450,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,500,000.00	9,450,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,500,000.00	9,450,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,500,000.00	9,450,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-5,500,000.00	-9,450,000.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	0.00

VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-15,022,618.37	-3,782,968.37
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	33,269,457.03	18,246,838.66
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,246,838.66	14,463,870.29

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,202,002,208.14	6,805,330.88	401,111,378.54	2,609,918,917.56
2	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,202,002,208.14	6,805,330.88	401,111,378.54	2,609,918,917.56
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,202,002,208.14	6,805,330.88	-452,265,847.29	1,756,541,691.73
4	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт			4,999,999,95	4,999,999,95
5	Тайлант үеийн үр дүн	0	0	-456,214,582.63	-456,214,582.63
6	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,202,002,208.14	6,805,330.88	-903,480,429.97	1,305,327,109.05

Гурав. Аудитын илрүүлэлт:

Завсрын аудитын талаар

Тус байгууллагад 2024 оны 2-р улирлын байдлаар хийсэн завсрын аудитаар өгсөн 245,538.8 мянган төгрөгийн 3 алдаа илэрсэн. Завсрын аудитаар илэрсэн 3 алдааг жилийн эцсийн тайланд залруулж ирүүлсэн байна. Үүнд:

- Тайлант хугацаанд үндсэн хөрөнгийн элэгдлийг 773.0 сая төгрөгөөр тооцож бүртгэхдээ элэгдлийн зардлыг нэмэгдүүлсэн ба хойшлогдсон татварын өрийг бууруулах бичилт хийгээгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4.3, 20 дугаар зүйлийн 20.2.4, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.
- Үнэ төлбөргүй хүлээн авсан 7,200.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хойшлогдсон татварын өрөнд дутуу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4.3, 20 дугаар зүйлийн 20.2.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.7 дах заалтыг зөрчсөн байна. санхүүгийн тайлангийн толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.
- Үндсэн хөрөнгийн худалдан авалтыг 9,450.0 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайлангийн үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн зардалд тохируулаагүй Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7 дахь заалтуудыг зөрчсөн Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар нийт 245,538.7 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан.

Аудитаар нийт 35,000.0 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлж аудитын явцад алдааг бүрэн залруулсан.

- *ОНХС-аас хийгдсэн хөрөнгө оруулалтын 35,000.0 мянган төгрөгийн бараа материалын дансанд бүртгэхдээ хойшлуулсан татварын өр төлбөрийн дансанд тусгаж бүртгээгүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7 гэсэн заалтуудыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.*

Аудитаар нийт 8,996.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 4,446.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 4,550.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Ажилтнуудад 2,066.2 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл цалин хөлсийг нотлох баримтад үндэслэлгүйгээр анхан шатны баримтын бүрдэлтгүйгээр олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 6 дугаар зүйлийн 6.4.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4 дахь заалтуудыг зөрчсөн Санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй зарцуулсан 2,066.0 мянган төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.2. Анхан шатны баримтгүй 2,379.8 мянган төгрөгийг шатахууны зардалд зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтуудыг зөрчсөн Санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй зарцуулсан 2,379.8 мянган төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1. Өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй /Аюултай хог хаягдал түр хадгалах зориулалттай олгосон 25000м² газрыг санхүүгийн тайланд үнэлж бүртгээгүй./.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.4.2, Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаал "Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал"-ын 4.2 дахь заалтыг зөрчсөн байна. Санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны зөвлөмжийг биелүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой.

1.1 Илрүүлэлт:

Биет бус хөрөнгөд бүртгэлтэй 3 нэр төрлийн 44,000.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулж бүртгэсэн бөгөөд элэгдлийн хугацаа дууссан / Ажлын зураг төсөв/.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 5.1.5, 20.2.4, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 7.1 дах заалт, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Биет бус хөрөнгийг данс бүртгэлд тусгахдаа ашиглах хугацаа тооцох эсэхэд анхаарч ажиллах, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө нөхсөн эдийн засгийн үр өгөөж хүртэж буй хөрөнгөнөөс цаашид ашиглах боломжтой хөрөнгийг үнэлж данс бүртгэлд тусгах

2. Бараа материалтай холбоотой.

2.1 Илрүүлэлт:

Бараа материалын эхний үлдэгдэл болох 4 нэр төрлийн 5780ш бараа материалын 7,110.0 мянган төгрөгийг ЭАЭЗ аргыг ашиглаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 дахь заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: ЭАЭЗ аргыг ашиглаж бараа материалыг бүртгэх

3. Дотоод хяналттай холбоотой.

3.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд ажилласан ажиллагсдаас 20 албан хаагчийн цалингийн картыг хэвлэж архивлаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтуудыг зөрчсөн . санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Тухайн жилд ажилласан ажилчдын цалингийн картыг бүрэн хэвлэж архивлах

Дээрх шийдвэрийн биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу шийдвэрийн хэрэгжилтийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд тус тус Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Тав.Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			